


ОЮУ ТОЛГОЙН ТУХАЙ ТОВЧХОН



■ Оюу Толгой нь Монгол Улсын өмнөд хэсэг, Өмнөговь аймагт нийслэл Улаанбаатар хотоос 600 километр зайд орших дэлхийн хамгийн том ашиглалтад бэлтгэж буй алт, зэсийн орд юм.

■ Оюу Толгойн олборлолт 2012 онд ил уурхайгаас эхлэх бөгөөд жилд 450,000 тонн зэс, 330,000 унц алт үйлдвэрлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ингэснээр дэлхийн томоохон зэс, алтны уурхайн нэг болно.

■ Оюу Толгой нь Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу Майнз болон Рио Тинто группын хамтарсан компани юм. Энэхүү төслийг Рио Тинто 2010 оны 10 дугаар сараас удирдаж эхэлсэн бөгөөд тус компани нь Айвенхоу Майнзын хувьцааны 48,5%-ийг эзэмшдэг.



Хаягдал өтгөрүүлэгч байгууламж



БАРИМТЫН ТОВЧООН

МОНГОЛЫН АЖИЛЛАХ ХҮЧ


- Үйлдвэрлэлийн үе шатанд нийт ажиллах хүчний 90 гаруй хувь буюу 3000 монгол ажилчид ажиллана. Оюу Толгой дээр нэг ажлын байрыг дагалдан дөрвөн ажлын байр бий болох судалгаа хийгдсэн.
- Оюу Толгой нь Монгол Улс дахь хамгийн том, өргөн цар хүрээ бүхий мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд олгож буй ур чадварын ихэнх нь хөрвөх боломжтой бөгөөд Мэдээллийн технологи, Байгаль орчны менежмент болон Нягтлан бодох бүртгэлийн салбарт ажлын байрууд бий болно.
- Ирэх таван жилийн хугацаанд боловсрол, сургалтын үйл ажиллагаанд 85 сая орчим ам.долларын хөрөнгө оруулалтыг хийх бөгөөд үүний хүрээнд 3 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв шинээр барих, 4 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Техник технологийн коллежийг өргөтгөн сайжруулах зэрэг ажлыг эхлүүлээд байна. Бид Монгол Улсын их дээд сургуулиудад суралцаж буй



БАРИМТЫН ТОВЧООН

120, гадаадын их дээд сургуулиудад суралцаж буй 30 монгол оюутанд тэтгэлэг олгохоор төлөвлөсөн.

- Рио Тинто болон Айвенхоу Майнз компаниуд төслийн бараа, үйлчилгээг худалдан авахад зориулан өдөр тутам дунджаар 8 сая ам.долларыг зарцуулж байгаа бөгөөд 250 сая ам.долларын татварын өмнөх ашгийг Монгол Улсын Засгийн газарт төлөөд байна.
- Бидний хэрэгжүүлж буй "Монголчуудад давуу эрх олгох санаачилгын" хүрээнд Өмнийн говийн эдийн засгийн хөгжлийг чухалчлан үздэг бөгөөд одоогоор Оюу Толгойд 1000 гаруй Монголын ханган нийлүүлэгч нар бүртгэгдсэн. Одоогийн байдлаар 1 тэрбум ам.доллар буюу нийт зарцуулсан мөнгөн хөрөнгийн (2,5 тэрбум) дөрөвний нэгийг орон нутгийн ханган нийлүүлэгч нарын нийлүүлсэн бараа, үйлчилгээнд төлсөн.
- Өмнөговь аймагт одоо хэрэгжиж буй дэд бүтцийн 12 төслийн 5-ыг нь 100% Монголын эзэмшил бүхий гэрээт компаниуд удирдан гүйцэтгэж байна.



Оюу Толгой ХХК
Моннис цамхаг
Чингисийн өргөн чөлөө-15
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар - 14240

Олон нийттэй харилцах хэлтэс
Утас: +976 11 331880
Факс: +976 11 331893
И-мэйл: OTLLCinfo@ot.mn
www.ot.mn